



БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.09.28 № 316
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030623


Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
МАН-ЫН 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Хөтөлбөрийн зорилго:

Сумын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хадгалж, иргэнээ дээдэлсэн, орчин үеийн мэдээ, мэдээллийн технологи, шинжлэх ухаанд суурилсан хөгжилтэй, тогтвортой амьжиргааг бүтээлч ажилтай, орлоготой иргэдтэй, оновчтой бүтэц бүхий мал аж ахуй, аялал жуулчлалд суурилсан эдийн засагтай байхад оршино.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төрийн болон хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, олон улсын хандивлагч байгууллагуудыг төсөл хөтөлбөртэй уялдуулан ажиллах юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ сумын төрийн болон төсөвт байгууллагуудын хамтын ажиллагаа, сахилга бат шийдвэрлэх үүрэгтэй.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ иргэд, айл өрх, албан байгууллагуудын идэвхи санаачилга, манлайлал ихээхэн үүрэгтэй байх ба ядуурлыг бууруулах, байгаль хамгаалах, бэлчээрийн менежментийг зохистой хийх, орчны бохирдлыг бууруулах, хувь хүмүүсийн манлайллыг дэмжих, алдаршуулах бодлогыг зарчим болгоно.

Сумын МАН-ын 2020-2024 он хүртэл хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйтай, байгалийн бохирдлыг эрс багасгаж сумын төвийн гудамж хорооллын замыг сайжруулсан, аялал жуулчлалын гол маршрутаар дэд бүтэц хөгжсөн, орон нутгийн аж ахуйн нэгжүүд, иргэдийн бизнес хөгжсөн өөрсдийгөө авч явах чадвартай болсон байна.

Нэг. Эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд

1.1. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуйн орчинг бүрдүүлж, мал аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн арьс, шир, сүлжмэл, нэхмэлийн чиглэлээр жижиг дунд үйлдвэрүүдийг байгуулах.

1.2. Суманд байгуулагдсан сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг дэмжиж үйл ажиллагааг нь тогтмолжуулах, малчдыг байнгын орлоготой болгох, ажлын байрыг нэмэгдүүлж бэлэн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах.

1.3. Байгалийн хүрмэн чулууг ашиглан барилгын материалын үйлдвэр байгуулах.

1.4. Байгалийн нөөцийг зохистой ашиглах, жимс жимсгэнэ, малын тэжээл тариалах чиглэлээр газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж, малын тэжээлийг 20 –оос доошгүй га талбайд тариалах.

1.5. Аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон жуулчдын тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын замын маршрутын дагуух дэд бүтэц, зам гүүрийн нөхцлийг сайжруулна.

1.6. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээ, авто болон явган хүний зам, замын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерийн суваг, гэр хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг сумын онцлогт тохируулан үе шаттай хэрэгжүүлнэ.

2 Хот байгуулалт , дэд бүтэц



10

2.1. Сумын дотор хатуу хучилттай замын сүлжээг нэмэгдүүлж, Хужирт – Бат-Өлзий чиглэлийн авто асфальтан замыг шинээр тавих.

2.2. Улаан голд гүүр барих.

2.3 . Сумын төвд хяналтын камерийн системийг нэмэгдүүлнэ.

2.4. Улаан ам, Зөрүүлэг багийн төвүүдийг хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу суурьшлын бүс болгоно.

2.5. Бүрэгтий багийн төвийг хэсэгчилсэн төлөвлөгөөг дагуу суурьшилийн бүс болгон, өндөр хүчдэлд холбоно.

2.6.Өвтийн Улаан хадны замыг засварлана.

2.7. Сумын төвийн гэрэлтүүлэгийг нэмэгдүүлж, алслагдсан гудамж, хорооллыг гэрэлтүүлэгтэй болгох.

2.8. Үйлчилгээний цогцолбор төв байгуулах. Үүнд: Үсчин, гоо сайхан, зурагчин, халуун ус, саун, массаж, фитнес, интернет кафе, кофе Shop, оёдол, кино театр, цайны газар/

2.9. Хүүхэд, залуучуудын спорт цогцолборын ордон байгуулах.

2.10. Сумын төвийн хэсэгт нийтийн бие засах газар шинээр барьж, айл өрх бүрийг боловсон ангилан ялгадаг хогийн савтай болгох.

2.11. Цагаан голд сумын төвийн дахин төлөвлөлтийг боловсруулж, суурьшилийн бүс бий болгон, жишиг хорооллуудыг бий болгох.

3 Хүнс хөдөө аж ахуй, хөдөлмөр эрхлэлт

3.1. Фермерийн аж ахуйг дэмжиж, мах, сүүний чиглэлийн малыг өсгөхөд дэмжлэг үзүүлнэ.

3.2 .Бэлчээрийн даац төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлж, оновчтой ашиглах, усан хангамжийг сайжруулах, хашиж хамгаалах, нөхөн сэргээхэд малчид, иргэдийн санаачилгыг дэмжиж ажиллана.

3.3. Сумын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худгуудыг шинээр гаргах.

3.4. “Нэг сум-нэгдсэн мал эмнэлэг” –ийн үйл ажиллагааг сайжруулж, дэмжлэг үзүүлж, малын гоц болон халдварт өвчнийг бууруулах, малын эрүүл мэнд, эрүүл хүнстэй байх бодлогыг барьж, мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг тогтмолжуулах.

4 Байгаль орчин ,аялал жуулчлал

4.1. Олон улсын өвөл, зуны спорт сургалтын цогцолбор төв байгуулах.

4.2. Сумын төвийн засмал замын дагуу ногоон байгууламжтай болох.

4.3. Сумын ТӨҮК-ны үйл ажиллагааг жигдрүүлж, хог хаягдал дахин боловсруулах цех байгуулах .

Хоёр. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд



2.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажллагааг дэмжинэ.

2.2. Сумын эрүүл мэндийн төвийг шаардлагатай оношлогоо эмчилгээ, лаборатори, мэс заслын багаж тоног төхөөрөмжөөр хангана.

2.3. Хөдөөгийн багийн эмч нарыг унаатай болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.4. Улаан амын багт 5-10 хүний ортой багийн эмнэлэг шинээр барих.

2.2 Боловсролын салбарын зорилтууд

2.2.1. 320 хүүхдийн сургууль шинээр барих.

2.2.2. 100 хүүхдийн дотуур байр шинээр барих.

2.2.3. 75 хүүхдийн Цэцэрлэг шинээр барих.

2.3. Төрийн үйлчилгээ

2.3.1. Төрийн албан хаагчдын ажлын байранд тавигдах шаардлагын дагуу аттестатчилж, мэргэжил, ур чадвар, ёс зүйг үнэлж, хариуцлагыг өндөржүүлэх.

2.3.2. Төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийг ажлын бүтээмж, иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанартай нь уялдуулж олгодог зарчим нэвтрүүлнэ.

2.3.3. 1 дүгээр багийн байр шинээр барина.

2.3.4. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ.

2.4. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд

2.4.1. Суманд бүртгэл, мэдээллийн онлайн системийг бүрэн нэвтрүүлж, иргэний эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг сумандаа чирэгдэлгүй үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.4.2. Гэмт хэргийн гол шалтгаан болсон архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын буруу зуршил нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, үнэт баялаг монгол ёс заншил ухамсрыг хүүхэд, залуучуудад төлөвшүүлж, зөв хүмүүжил олгох ажлыг иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, орон байр, эд хөрөнгийн хулгай илрүүлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журмыг хангах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хяналтын камерийн системийг нэмэгдүүлнэ.

2.4.4. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг сайжруулах, малыг коджуулах технологийг нэвтрүүлнэ.

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМ